



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар A/117

Хажуу шинэ ус

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны A/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Говь-Угтаал сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байршилтай (Жирэмийн цагаан даравгай), (Бөөрийн толгод)-д гэх 2 газрын иргэн Баатарын Ариунжаргал (ЗВ82020128)-ийн өвөлжөө хаваржааны зориулалттай 4807000317, 4807000318 нэгж талбарын дугаартай тус тус 5000 м.кв (0.5 га) газрыг иргэн Баянмөнхийн Билгүүдэй (ЗН05280211)-т зориулалтаар нь шилжүүлж 3 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Дээрх газрын эзэмшигч Б.Билгүүдэйд эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Н.Лхагва-Учрал)-д, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Т.Цэрэнчунт)-д үүрэг болгосугай.

3.Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу ашиглаж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч (Б.Билгүүдэй)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны A/100 дугаар захирамжийн иргэн Б.Ариунжаргал-д холбогдох хэсэг мөн газар эзэмших эрхийн 0353859, 0353860 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Т.АРИУНАА

482401117